



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 09 өдөр

Дугаар A/501

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн прокурорын газрын түүхт 90 жилийн ойг тохиолдуулан орон нутгийн прокурорын байгууллагыг бэхжүүлэх, Монгол улсын хууль, тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, төрийн хяналт шалгалтыг үр дүнтэй, чанартай гүйцэтгэх үйлсэд өөрийн сэтгэл оюун, хүч хөдөлмөрөө дайчлан хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Булган сум дахь сум дундын прокурорын газрын туслах ажилтан Доржийн Булгансүвд, жолооч Батсуурийн Хатанбаатар, бичиг хэргийн ажилтан Баатарцолын Батзул, аймгийн прокурорын газрын үйлчлэгч Д.Баярболд, жолооч Б.Лхагвадаш, захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан С.Сарантуяа нарыг аймгийн Засаг даргын "Хүндэт өргөмжлөл"-өөр шагнахад 180,000 төгрөг (нэг зуун наян мянга)-ийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 180,000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2637
Zah A/501 Bo